- Тус хэлтсийн Зүүнхараа зангилааны 4 алба хаагч, зохицуулагч-цагдаа 4, үйлчлэгч 2, суудлын цагдаа 10-ын ар гэрээр орж амьдралын түүхийн судалгаа хийв.
- ЦЕГ-ын ХНСХ-ийн мэдэлд “Төрийн тусгай албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллан 348 иргэнээс сэтгэл зүйн сорил авах, цагдаагийн байгууллагад эргэн орох хүсэлт гарсан 118 иргэнтэй ярилцлага хийсний 8 иргэний дүгнэлтийг гаргав.
- “Цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүй, харилцааны ур чадварыг дээшлүүлэх” сургагч багшийн вакумжуулсан 3 хоногийн сургалт болон сургагч багшийг чадавхжуулах 3 өдрийн, ХСИС байгууллагуудын сэтгэл зүйчдийн 2 өдрийн, Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх 5 өдрийн сургалтанд тус тус хамрагдав.
- Хэлтсийн бие бүрэлдэхүүнд ЦБҮАЖ 922-оор хуучин хэрэглэж байсан 921-тэй харьцуулсан танилцуулга хийж, хэлэлцүүлэг явуулан, батлагдсаны дараа албаны сургалт зохион байгуулав.
- Гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн алба хаагчдад “Гэрч, хохирогч, сэжигтэнтэй харилцах ажиллагаа, анхаарах асуудал” сэдвээр 2 цагийн сургалт оров.
- ХСИС-ийн Цагдаагийн сургуулийг төгсөх ангийн сонсогчдоос авах ажлын хэсэгт орж ажиллан 201 сонсогчоос сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох 5 төрлийн тест авч, 9 сонсогчийн сэтгэл зүйн дүгнэлтийг хугацаанд нь чанартай хийж өгөв.
- “Тоглоом” цуглуулах хандивын үйл ажиллагаа зохион байгуулж, 84 алба хаагч хамрагдан, УБХЦГ-ын ГБХТХ-ийн хамгаалах байранд хүлээлгэн өгөв.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Жижүүрийн шуурхай удирдлагын хэсгээс:

Тус цагдаагийн хэлтсийн жижүүрийн шуурхай удирдлагын хэсэгт гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 197 мэдээ, мэдээлэл ирснээс гэмт хэргийн шинжтэй-74, зөрчлийн-123 дуудлага мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулж хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн.

Төвөөс дотоод сүлжээгээр ирүүлсэн гэмт хэргийн 2473, хүн эд зүйлийн-1855, нийт 4328-н зарлан мэдээллийг хүлээн авч, үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн болон хэсгийн цагдаа, суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа болон өртөө зангилаадад ажиллаж байгаа алба хаагчдад шуурхай зарлан мэдээлсэн.

Хариуцлагатай зохицуулагч нар байгууллагын дотоод аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, өртөө зангилаадад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нартай байнгын холбоотой ажиллаж, саатуулах байрны үйл ажиллагаанд хяналт тавьж дарга, удирдлагыг мэдээллээр хангасан.

Хүүхдийн албанаас:

Монгол улсын засгийн газрын 58 дугаар тогтоол “Олон нийт–цагдаа” хамтын ажиллагааны хүрээнд төмөр замын хүүхдийн байгууллагатай хамтран байгуулсан түншлэлийн гэрээний дагуу 2015 оны 02 сарын 10-ны өдөр Улаанбаатар төмөр замын зорчигч үйлчилгээний төв буудлын хүлээлгийн танхимд 08:30 цагаас 12:00 цагийн хооронд “**Нээлттэй өдөр-1**” арга хэмжээг зохион байгуулж 12 төрлийн 1200 ширхэг гарын авлага материал тарааж 35 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 45 иргэнийг эмнэлэгийн анхны үзлэгт хамруулж нийт 70 иргэнээс санал асуулга авч ажилласан. 2015 оны 03 сарын 18-ны өдөр Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөний ачаа тээвэр, зорчигч үйлчилгээний ангид “**Нээлттэй өдөр-2**” арга хэмжээг зохион байгуулж 12 төрлийн 1200 ширхэг гарын авлага материал тарааж, Бидний орчин-Хүчирхийлэлгүй орчин аяны хүрээнд хүчирхийллийн эсрэг яриа таниулга хийсэн. Уг арга хэмжээнд 65 ажилтан хамрагдаж 760 иргэнээс санал асуулга авч ажилласан.

Монгол улсын засгийн газрын 58 дугаар тогтоол “Олон нийт–цагдаа” хамтын ажиллагааны хүрээнд төмөр замын хүүхдийн байгууллагатай хамтран байгуулсан түншлэлийн гэрээний дагуу 2015.01.14-нд хүүхдийн байгууллагын төвд байрлах 5 цэцэрлэг, захиргаа удирдлагын газрын нийт 23 ажилтан, Гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн хэрэг бүртгэгч, цагдаагийн дэслэгч Э.Тулгатай хамт УБТЗ-ын төв засварын газрын 70 ажилтан нийт 93 алжилтнуудад төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн 2014 онд хийсэн ажлын тайланг сонсгосон болно.

Улаанбаатар төмөр замын зорчигч үйлчилгээний төв буудал дээр дэмий сэргүүцэж явсан Янжинпүрэвийн Батзориг /эр, 12нас/, Мягмарсүрэнгийн Энхтүвшин /эр, 11 нас/, Гантулгын Бөхбат /эр, 12 нас/, Гантулгын Энх-Амгалан /эр, 12 нас/, Тунгалаг Билгүүн /эр, 10 нас, Саруулын Дөлгөөн /эр,12 нас/, Лхагвацэрэнгийн Энхтөр /эр, 14 нас/, Мөнхсоёлын Энхжаргал /эр, 11 нас/, Энхбаярын Түвшинбилэг /эр, 14 нас/ нарын 9 хүүхдийг бүртгэл судалгаанд авч, 8 хүүхдийг ар гэрт нь, Т.Билгүүнийг хүчирхийллийн эсрэг хамгаалах байранд хүлээлгэн өгч ажилласан.

Архивын баримт бичгийн жагсаалтаар 2014 оны байнга хадгалах 2, түр хадгалах 7 баримт бичгийг товъёоглон үдэж бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг 12 сараар гаргаж тасгийн даргаар хянуулж, хэлтсийн даргаар батлуулсан.

2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 13:00 цагт Хэлтсийн алба хаагчдыг эрүүл, зөв амьдралын хэвшилд оруулах, бие бялдарыг хөгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зүй ёсоор өнгөрөөх, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажилд хамруулах зорилгоор төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн даргын 2015 оны 01 дүгээр сарын 13-ны тушаалаар батлагдсан соён гэгээрүүлэх ажлын 10 багын хооронд зохион байгуулагдах гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан.

Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудалд жэв журмын байцаагчаар 12 удаа үүрэг гүйцэтгэж суудал үүрэг гүйцэтгэхээр явж байгаа цагдаа нарын ажлын бэлтгэл, цаг ашиглалтад хяналт тавь, вокзалын ойр орчимд эргүүл шалгалт хийж ажилласан.

Улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлд 2015 онд насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөвт 3,200,000 төгрөгийн санал өгч хэлтсийн даргаар хянуулсан.

2015.04.26-2015.05.06-ны хооронд “Цэцэрлэг-1,2” арга хэмжээг Улаанбаатар төмөр замын замын даргын үзлэгээр явж өртөө, зангилаадад үүрэг гүйцэтгэж хүүхдийн байгууллагын хойд чиглэлийн 10 цэцэрлэг, урд чиглэлийн 11 цэцэрлэгийн ажлын байрны хариуцлага, ёс зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажил, харуул сахиулын ажлын байрны зааварчилгааг шалгаж 7 цэцэрлэгийн 12 зөрчил илрүүлж хүүхдийн байгууллагын дарга С.Отгонтуулд мэдэгдэж засуулах арга хэмжээ авсан.

Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Улаанбаатар төмөр замын аюултай бүсийн дэглэм, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Чулуу” хэсэгчилсэн арга хэмжээ зохиож Мандал өртөө, Ногоонтолгой зөрлөг, 324, 347 дугаар км, Жаргалант, Түнхэл өртөө зэрэг газруудын ойр орчимд байдаг Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд вагон зам дээр чулуу тавих, галт тэрэгний цонх хагалахын хор холбогдолыг таниулж бага, дунд, ахлах ангийн нийт 21 ангийн 815 хүүхдэд сургалт орсон.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны А-115 дугаар тушаалаар вагон ресторануудад спиртын өндөр болон сул агууламжтай согтууруулах ундааг худалдаалахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан суудлын галт тэргэнд гэмт хэрэг, зөрчлийн гаралт ихсэж болзошгүй тул Улаанбаатар төмөр замын нийтийн хоолны төвийн 66 ажилчдад Монгол улсын архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар яриа таниулга хийсэн.

“Олон нийт-цагдаа хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд төмөр замын ажилтан, цагдаагийн хэлтсийн алба хаагчдын хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүүхэддээ нөлөөлөх ажилд сайн дураар оролцуулах, тэдний идэвхийг өрнүүлэх, санал санаачлагыг нь дэмжих зорилгоор “**Би эх орны эзэн**” сэдвээр 06-09 насны хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, 10-12 насны хүүхдүүдийн дунд зохион бичлэгийн уралдаан, 13-16 насны хүүхдүүдийн дунд эссэ бичлэгийн уралдаан зохион явуулж нийт 171 хүүхэд оролцож 6 байр шалгаруулсан.

МУ-ын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлыг тайлагнах, хууль эрх зүйн болон Цагдаагийн байгууллагад хийгдсэн шинэчлэл, үйл ажиллагааг сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцдог иргэн, байгууллага, сайн дурын бүлгийн үйл ажиллагааг алдаршуулан сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхижүүлэх, хамтын ажиллагааны ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг ойлгуулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Улаанбаатар төмөр замын зорчигч үйлчилгээний төв буудал, Замын-Үүд, Сайншанд, Айраг, Олон-Овоо, Чойр, Түнхэл, Зүүнхараа, Дархан, Сэлэнгэ, Эрдэнэт өртөө, зангилаадад “**Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр**” өдөрлөг зохион байгуулах арга хэмжээний удирдамж боловсруулан 2015.06.05-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:

Тус хэлтсийн 2015 оны гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын хүрээнд хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Г.Басбиш, саатуулах байрны дарга, цагдаагийн хошууч Б.Тунгалаг, хүүхдийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Азжаргал нараас төлөвлөгөөнд оруулах саналыг авч нэгтгэн хэлтсийн дарга, гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газраас баталсан Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр, Замын даргын 99 тоот албан даалгаврын дагуу Улаанбаатар хот дахь 24 байгууллагыг оролцуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанарыг эрчимжүүлэх, “Түншлэлийн гэрээ”-г хэрэгжүүлэх зорилгоор төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийг 30 офицерт хуваарилан өгч хуваарийг хэлтсийн даргаар батлуулан “Олон нийтийн эргүүл”-ийн хуваарийн дагуу Амгалан, Толгойт, төвийн гэсэн 3 чиглэлд 19-00 цагийн хооронд офицерүүдийн удирдлаган доор олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагчийн шийдвэрээр чиглэл цагийг тогтоон, эргүүл шалгалтаар 35 удаа ажиллахаас 21 удаа 21 офицер 31 төмөр замчин ажиллаж, 8 зөрчил илрүүлсэн байна. Олон нийтийн эргүүлийн хугацаанд зөрчил дутагдал заагдсан 5 байгууллагад албан мэдэгдэл өгч, 3-н байгууллагаас мэдэгдлийн хариуг авсан.

“Түншлэлийн гэрээ”-ний дагуу байгууллага хариуцсан офицеруудаар Улаанбаатар төмөр замын 27 байгууллага, өртөө зангилаадад цагдаагийн хэлтсийн

2014 оны үйл ажиллагааны тайланг тавих үүрэг чиглэл өгч, тайлан тавьсан байдал, түүнээс гарсан санал, хүсэлтийг илтгэх хуудсын хамт авч, нийт 27 байгууллагын 3550 төмөр замчид хамрагдсан талаарх илтгэх хуудсыг нэгтгэн хэлтсийн даргад танилцуулсан.

Төмөр замын хэмжээнд сүүлийн 2 жилд гарч байгаа гэмт хэргийн талаарх судалгааг гарган цаашид авах арга хэмжээний талаар хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. 2015 онд зохион байгуулах “Нээлттэй хаалганы өдрийн хуваарийг хийж батлуулан тасаг албадад өгсөн.

Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудалд Нийтийн хэв журам хамгаалах тасгаас “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулахад 70-н төмөр замчин хамрагдаж 35 иргэнд эрх зүйн зөвөлгөө өгч, саатуулах байрны эмч, цагдаагийн дэслэгч Ж.Мөнхтуяа 45 иргэнийг эмчийн үзлэгт хамруулан 70 иргэнээр санал асуулгын хуудас бөглүүлэн сэтгэл зүйч Ц.Тогосд дүгнэлт гаргуулахаар өгсөн. Тамхи татахыг хориглосон наалт 50 ширхэг, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх гарын авлага 30, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамдаа боршур 40 ширхэг, нийт 12 төрлийн 1200 ширхэг санамж материалыг олон нийтэд тараан ажилласан. Нээлттэй хаалганы өдөр-3”-ийг Улаанбаатар замын үүд өртөөнд зохион байгуулж, Өртөөний ачаа тээврийн цех, ачиж буулгах ангиудын төмөр замчид болон 40 төмөр замчин хамрагдлаа. “Сар шинэ” арга хэмжээний хүрээнд галт тэргээр зорчих иргэдийн тоо ихэсч байгаатай холбогдуулан зорчигчдод хулгайд эд зүйлээ алдах, эд зүйлээ мартаж буухаас болгоомжилж, сонор сэрэмжтэй үйлчлүүлэх талаар “Ган зам”, ЦЕГ-н дуудлага студтэй хамтран сэрэмжлүүлэг өгсөн.

Иргэдийг хууль бус хориотой ангийн эд зүйл хилээр нэвтрүүлэхгүй байх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЦЕГ-н хэвлэл мэдээллийн албатай хамтран иргэдэд мэдээлэл өгсөн. Мөн Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын өндөрлөсөн давцан болон арын талбайд байрлах хогийн саван дээр тамхи татахыг хориглоно гэсэн 25 ширхэг санамж, гал тэрэгний үйлчлэгч нарт хулгайн гэмт хэргээс хамдаа урьдчилан сэргийлье боршур 140 ширхэгийг тараан галт тэрэгний купе бүрт байрлуулсан.

“Вокзал-1” хэсэгчилсэн арга хэмжээг 2015 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд хэв журмын офицер, цагдаа нарт үүрэг чиглэл өгч хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Г.Басбиш, УБЗҮТБ-н ээлжийн ахлагч Байгалмаатай хамтран вокзалын гэрэлтүүлгийг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан мэдэгдэл хүргүүлсэн.

Суудлын вагон депо, Гал унтраах анги, Төв эмнэлэг, Хангамжийн алба, Төв засварын газар, Вагон ашиглалтын депо, Ачиж буулгах анги зэрэг 10 байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл хүргүүлж хариуг авсан.

Монгол улсын Засгийн газар, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, цагдаагийн байгууллагын нэр хүндийг өргөж, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх зорилгоор “Бидний орчин хүчирхийлэлгүй орчин аяныг зохион байгууллаа.

“Бидний орчин хүчирхийлэлгүй орчин” арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулсан. Арга хэмжээнд санаачлагч байгууллагаар ЦЕГ, УБТЗ, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс, Хүүхэд, залуучууд хөгжил дэвшлийн төв, Монголын сурагчдын холбоодыг оролцуулж, хамтрагч байгууллагаар “Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв”, “Итгэл, найдвар, хайр төв”, “Монголын ирээдүй эрүүл хүүхэд төв”, “Цөлийн сарнай” сан зэрэг байгууллагыг оролцуулан ажилласан.

“Бидний орчин-хүчирхийлэлгүй орчин” аяны хүрээнд Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Г.Басбиш, хүчирхийлэлийн эсрэг үндэсний төвийн сургагч багш Одончимэг нартай хамтран автордио 96,3 FM-ээр жолооч нарын дунд хүчирхийлэлийн тухай ойлголт сэдвээр нэвтрүүлэг бэлтгэн оролцсон.

Суудлын вагон депо болон галт тэргэнд үүрэг гүйцэтгэдэг цагдаа нарт гэмт хэрэг зөрчлийн эсрэг хамтдаа боршурыг бусад төрлийн санамж материалын хамт 1300 ширхэгийг тараасан.

УБЗҮТБ дотор байрлах “Уянгацэрэн” интернэшнл ББСБ-ийн захирал Уянгад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 30 минутын сургалт,

Аяны хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн сэтгэл зүйч Санчир, хуулийн зөвлөх Одончимэг нартай хамтран суудлын вагон депогийн галт тэрэгний дарга, вагоны үйлчлэгч зэрэг 120, ус хангамж эрчим хүчний 1 дүгээр ангиийн 100 ажилтан, улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын 70 явуулын кассер, тээшийн ажилтан нарт “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль” болон “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан.

“Ахмад үеэ сонсое” албан бичгийн дагуу бэлтгэл хурандаа Доржийг урьж алба хаагчдад мэдээлэл хийлгэж санал солилцсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 оны хагас жилд “Автобусны зогсоол” “Сар шинэ” “Нийтийн тээвэр” “Вокзал-1” “Согтуу-1” “Зөрчил” “Хяналт шалгалт”, Илрүүлэлт- оргодол”, “ Шалгалт”, “Урд чиглэлд “ Зөрчил”, “ Согтуу-2”, “ Бидний орчин хүчирхийлэлгүй орчин аян” , Улаанбаатар татах хэсэгт “ Хяналт шалгалт-2” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 15 удаа зохиож, үр дүнг тооцон ажиллаа.

“Ган зам сонин”-д 5, өдрийн сонинд 2, залуу.com мэдээ, tv 1, 8, 9, nbs телевизүүдэд мэдээ, цагдаагийн ерөнхий газрын дуудлага студид 2 удаа сэрэмжлүүлэг өгсөн. Суудлын галт тэрэгний радио үзелээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөгжимт сэрэмжлүүлэг хийлгэж Зорчигч тээврийн албаар хянуулан, СВД-д хүргүүлсэн.

Албадан саатуулах байрны ажлын талаар:

Тус цагдаагийн хэлтсийн албадан саатуулах байрны алба хаагчид нь МУ-ын Цагдаагийн албаны тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Захиргааны журмаар албадан саатуулах тухай журам код-623 болон бусад холбогдох

хууль тогтоомжууд, 2015 онд Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа тушаал шийдвэрүүд болон ажлын чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Саатуулах байр нь архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 1145 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас 1129 хүнээс 4,683,200 төгрөгний төлбөр гаргуулан санхүүгийн албанд тушааж төлбөр төлөлт 98 %- тай ажилласан.

Нийт албадан саатуулагдсан 1129 иргэдийн албадан хүргэгдэж ирсэн шалтгааныг тодруулбал:

1.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан –214

2.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, гэмт хэрэг зөрчилд холбогдсон - 188

3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон – 320

4. Гудамж, талбай олон нийтийн газраас-390 иргэд тус тус хүргэгдэн ирж саатуулагдсан байна.

5. Асран хамгаалагчид нь 17 иргэнийг хүлээлгэн өгсөн.

Саатуулагдсан 1129 иргэдийн талаархи мэдээлэлийг ЦЕГ-ын Захиргааны тоо бүртгэлийн санд оруулж, хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах байцаагч цагдаагийн ахмад Ц.Сайханзоригтой 1129 эмгтэйчүүдийн мэдээлэлийг тулгаж хяналт тавин ажилласан. Төлбөр төлөөгүй 4 эмэгтэй иргэний хорооны засаг даргын тодорхойлтыг гаргуулж картанд хавсаргасан, 4 эмэгтэйн төлбөр болох 16.600 төгрөгийг нөхөн гаргуулан төрийн сан, санхүүд тушаасан.

Согтуугаар танхайрч цагдаагийн алба хаагчийн эрх чөлөөнд халдсан 2 иргэнийг гэмт хэрэгтэй тэмцэх тасагт шилжүүлж согтуугаар танхайрсан 2 эмэгтэйг захиргааны зөрчил хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн.

Саатуулах байранд саатуулагдах хугацаандаа цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж танхайрсан 213 эмэгтэйд ЗХТХ-ийн 21.1, 30.2.1-р зүйлийн дагуу 1.065.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч төлбөрийг тухай бүрт нь төрийн санд тушааж санхүүд тооцоо нийлж ажилласан.

Архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд:

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр хэлтсийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын төлөвлөгөөнд 5 ажил тусган УБТЗ-ын Удирдах Газрын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлд уг 5 асуудлыг шийдвэрлүүлэх санал хүргүүлэн ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр УБТЗ-ын 3 байгууллагын 125 ажилчин, алба хаагчдад яриа танилцуулга

хийж, зурагт хуудас 28 ш, санамж зөвлөмж-125ш, гарын авлага 75 ш тус тус тараан өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Албадан эрүүлжүүлэгдсэн 1129 иргэний гар, хурууны хээ болон зургийг Шүүх шинжилгээний папилон санд оруулж бүртгэл судалгаанд хамруулан ажилласан.

2015 оны эхний хагас жилийн хугацаанд саатуулагдсан 1129 иргэнд архидаг согтуурахаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж 250 ширхэгийг тараан, “Архи эд эрхтэнд хэрхэн нөлөөлөх вэ?, Архи амьдарлыг хэрхэн үгүй хийж буй тухай, архины зохистой хэрэглээний тухай, гэр бүл хүүхдэд архи яаж нөлөөлөх вэ? зэрэг 7 сэдвээр саатуулах байрны эмч нараар ярианы сэдэв бэлтгүүлэн радио үзэлээр өдөр бүр яриа таниулга хийж ажилласан. Саатуулагдсан иргэдэд “Гэр бүл хувь хүн хөгжлийн төв” ТББ-ын сургагч багш нараар 2 удаагийн сургалтаар 8 иргэнийг хамруулсан. НХЖХ-тасгийн хэв журмын офицеруудтай хамтран “Нээлттэй өдөр” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад оролцож 42 иргэнд эмчийн үзлэг хийж ажилласан.

Замын цагдаагийн албанаас:

2015 оны эхний хагас жилд гудамж замд хуваарийн дагуу 2 офицер, 5 зохицуулагч цагдаа ажиллаж, зөрчил гаргасан 4226 хүнийг 31,681,000 төгрөгийн бэлэн бус хэлбэрээр торгож, АСАP сангаар эрэн сурважлагдаж байсан хүн 2, согтуугаар автомашин жолоодсон 20, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 40 зөрчил тус тус илрүүлэн тээврийн хэрэгслийг саатуулж, БГД-ийн замын цагдаагийн тасагт шилжүүлж ажиллаа.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 10 сарын 15 өдрөөс хэрэгжих тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжид заасны дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд хяналт шалгалт хийж нийт 991 зөрчил илрүүлэн бэлэн бусаар зөрчил гаргасан 991 хүнийг 7,928,000 төгрөгөөр торгож ажлын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Төмөр замын байгууллагаас гаргасан төмөр замын гарам зөрчсөн гомдол мэдээлэл 74-ыг хүлээн авч шалган шүүхээр баривчилсан 1, мэдээлэл тогтоогдоогүй 1, шийтгэврээр 57 хүнийг 910,000 төгрөгөөр торгож, 15 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэлээ.

Зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Автобусны зогсоол”, “Сар шинэ”, “Нийтийн тээвэр”, “Вокзал-1”, “Согтуу-1,2,3,4,5”, “Төмөр замын гарам” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцож ажилласан.

Төмөр замын цэцэрлэгүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2015” тэмцээнийг зохион байгуулж, Төмөр замын “Ган зам” цэцэрлэг Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд орж тусгай байранд шалгарсан.

Төмөр замын удирдах газар дээр зохиогдсон гармын мэдлэг дээшлүүлэх зөвлөгөөнд оролцсон. Замын 2-р ангийн гармын жижүүрүүд, Замын 4-р ангийн жолооч

нар, Зорчигч үйлчилгээний төв буудлын арын төлбөртэй авто зогсоолын төлбөр хураагч нар, төмөр замын дотуур байрны 1-8-р ангийн хүүхдүүдэд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрэм, анхаарах зүйлийн талаар сургалт зохион байгуулж, 4 удаагийн сургалтанд нийт 170 хүн хамруулсан.

Төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, анхаарах зүйлийн талаар Нийтийн тээврийн Автобус-1,3, Тэнүүн дэлгэр, Эрдэм транс, Блюбус, Гацуурт, Петровис, Хүннү конгрейт зэрэг байгууллагуудын жолооч нарт 11 цагийн сургалт зохион байгуулж, 798 хүн хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу Цагдаагийн хэлтсийн нийт алба хаагчдаас алба ба амины тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодохгүй байх талаар 2 удаа баталгаа авч ажилласан.

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын БГД-ийн ЗЦТ-тай хамтран Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Вокзалын арын нийтийн тээврийн буудал, Варьете төвийн зүүн талын автозамын чиглэл хөдөлгөөнийг өөрчлөх, түгжрэлийг бууруулах талаар 8 тэмдэг тавиулж, 1 ширхэг хаалт хийж өдөр бүр хяналт шалгалт хийсэн.

Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 25-р суваг телевизтэй хамтарч “Хүсээгүй дайн” нэвтрүүлэг зохион байгуулж иргэд жолооч нарт сэрэмжлүүлэг болгон хүргүүлсэн.

Замын цагдаагийн газрын фэйс бүүк, Авто радио FM-96.3-аар төмөр замын гарам нэвтрэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг хэрэгжүүлэх талаар шторкийг өдөр тутам явуулсан.

УБТЗ-ын Замын 2-р анги, Дохиолол холбооны 2-р ангитай хамтран Нийслэл хотын дотор байрлах төмөр замын 8 гармын тэмдэг тэмдэглэл, гэрэл болон дуут дохио, хаалт, хашилт зэрэгт үзлэг шалгалт хийн акт тавьж ажилласан.

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Жаргалсайханаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар төмөр замын төв буудал орчмоос зөвшөөрөлгүй зорчигч тээвэрлэсэн 8 жолоочийн материалыг тоотоор нийслэлийн тээврийн газар болон Авто тээврийн үндэсний төвд хүргүүлж, БГД-ийн Замын цагдаагийн тасагт 37 жолоочийн бичиг баримт шилжүүлж арга хэмжээ тооцуулж өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

Төмөр замын авто тээвэр үйлчилгээний төв, Олон улсын галт тэрэгний тасалбар түгээх төв зэрэг байгууллагуудын алба хаагч, жолооч нарт цагдаагийн хэлтсийн 2014 онд хийсэн ажлын тайланг танилцуулж хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар яриа хийж санал хүсэлтийг авч ажилласан.

Төмөр замын зорчигч үйлчилгээний төв буудал, Авто тээвэр үйлчилгээний төв, Олон улсын галт тэрэгний тасалбар түгээх төв зэрэг байгууллагуудтай хамтран төмөр замын 12 байгууллагуудын харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, хяналтын камерийн ашиглалтад үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг засуулж ажилласан.

Унгар улсын ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Болгар улсын ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Энэтхэг улсын ерөнхий сайд нар манай улсад айлчлал хийх үеийн А зэрэглэлийн хамгаалалт зохицуулалтанд 2 офицер, 5 зохицуулагч ажиллаж давхардсан тоогоор 46 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж зөрчил дутагдалгүй ажилласан.

Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 8 байгууллагад албан мэдэгдэл шаардлага өгч ажилласан.

Цаашид хийх ажил:

1. ЦЕГ-аас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн бодитой үр дүнтэй ажиллах.

2. Цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар албан даалгавар, санхүүгийн албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллах.

3. Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын дагуу байгууллагын төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавихад “Шилэн дансны хуулийн”-ийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.

4. Төсөв, санхүүтэй холбоотойгоор урсгал зардлын тооцоололтыг төсвийн тодотголд оруулж, төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлтийг төсөвт бодитой тусгах, хэмнэлттэй зарцуулах.

5. Алба хаагчдын эрүүл мэнд, бусад даатгал: 2015 онд цагдаагийн нийт алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулах.

6. Тээврийн прокурорын байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн аяны хүрээнд түдгэлзүүлсэн хэргийг илрүүлэх, шийдвэрлэх, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч хяналтын прокурорын хамтын ажиллагааг сайжруулах.

7. Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нараас гомдол мэдээллийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэх, шалгаж шийдвэрлэж байгаа гомдол мэдээллийн 50-с дээш хувийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах.

8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн нийгэм, олон нийт рүү чиглэсэн ажил зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах зэрэг болно.

Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс